



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 678

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, 2022 оны 204 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчит байгууллага, аж ахуйн нэгжээс татан төвлөрүүлсэн 12 нэрийн, нийт 499,961,895.32 (дөрвөн зуун ерэн есөн сая есөн зуун жаран нэгэн мянга найман зуун ерэн таван төгрөг гучин хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ, 480,837,668.78 (дөрвөн зуун наян сая найман зуун гучин долоон мянга зургаан зуун жаран найман төгрөг далан найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.“Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг, холбогдох байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Автомашинны төлбөр, хураамжийг бүрэн барагдуулж, зөрчлийг арилган, улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлийг шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

2.4.Энэ тогтоол гарсантай холбогдож Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 449 дүгээр тогтоолын хавсралтын 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 51, 52, 53 дугаар мөрийг хүчингүй болсонд тооцох.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг бөлгөсугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

31-р хуралдаан
13.08.2022

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн
6.7.8 дугаар тогтоолын хавсралт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчийн байгууллага,
аж ахуйн нэгжээс татан төвлөрүүлсэн, балансаас балансад шилжүүлэх автомашины жагсаалт

№	Шилжүүлэн өгөх байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн, ашигласан он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	"Дарханы дулааны цахилгаан станц" ТӨХК	Соната-6 NF /Хьюндай/, 8811ДАА	2005/ 2005	28,779,705.62	26,065,356.73	2,714,348.89
2	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	Хюндай Соната-7, 1563УНУ,	2010/ 2011	40,707,630.00	40,707,630.00	0.00
3	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	Хюндай Соната-7, 8753ОРО,	2011/ 2011	44,736,320.00	44,736,320.00	0.00
4	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	Ниссан Теана, 2140ОРО,	2013/ 2019	79,741,650.00	74,430,077.00	5,311,573.00
5	Гадаадын иргэн, харьяатын газар	Приус-20, 2954УНС,	2010/ 2019	12,500,000.00	5,208,333.30	7,291,666.70
6	Санхүүгийн зохицуулах хороо	Тоёота Камри, 0913УНУ,	2011/ 2011	52,140,000.00	52,140,000.00	0.00
7	Орхон аймгийн Төрийн аудитын газар	Vanguard, 46-99ОРА,	2008/ 2016	29,000,000.00	28,334,589.11	665,410.89
8	Замын-Үүд чөлөөт бүс	Тоёота Камри, 03-80УБЗ,	2005/ 2005	32,967,000.00	32,967,000.00	0.00
9	Төрийн банк	Лексус ES-330, 0542УБА,	2004/ 2004	49,488,338.85	49,488,338.85	0.00
10	Монгол улсын багшийн их сургууль	Сонато-6, 2353УНУ,	2005/ 2007	2,299,413.85	574,853.52	1,724,560.33

11	Төрийн банк	ЛЕКСУС SL-460, 1100УНЯ, /88-93УБА/	2007/ 2008	124,601,837.00	124,601,837.00	0.00
12	Замын-Үүд чөлөөт бүс	Ниссан максима, 0769УНУ,	2006/ 2007	3,000,000.00	1,583,333.27	1,416,666.73
	Нийт дүн			499,961,895.32 (дөрвөн зуун ерэн есөн сая есөн зуун жаран нэгэн мянга найман зуун ерэн таван төгрөг гучин хоёр мөнгө)	480,837,668.78 (дөрвөн зуун наян сая найман зуун гучин долоон мянга зургаан зуун жаран найман төгрөг далан найман мөнгө)	19,124,226.54 (арван есөн сая нэг зуун хорин дөрвөн мянга хоёр зуун хорин зургаан төгрөг тавин дөрвөн мөнгө)